МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР
14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2022 09-21 № 05/12223
танай _____-ны № _____-т

ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Ч.ЗОЛБАЯР ТАНАА

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянасан тухай

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын яамны үйл ажиллагаа, харьяа байгууллагын төсөл хөтөлбөрийн үйл ажиллагааны хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Дэндэвийн Цэрэнпүрэвийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч Д.Цэрэнпүрэв нь зар сурталчилгаа, компьютерын үйлчилгээ, хэвлэлийн үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх “XXXXX” ХХК-ийн 100%-ийн хувьцаа эзэмшигч, захирлаар, зар сурталчилгаа, газар тариалан, гадаад худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх “Хуртариа” ХХК-ийн 100%-ийн хувьцаа эзэмшигч, захирлаар тус тус бүртгэлтэй байх тул Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19, 20 дугаар зүйлд заасан хязгаарлалтыг хэрэгжүүлж, тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж, хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ОРЛОГЧ БӨГӨӨД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЛБАНЫ ДАРГА, АХЛАХ КОМИССАР Л.СҮХ-ОЧИР

УХАА422 5120829

1422003017153